

**02.3.2.БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИЙДЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Шалгуулагч этгээдийн этгээдийн нэр:

Хяналт шалгалт хийх объектын нэр:

Шалгуулагч этгээдийн регистрийн дугаар:

Хяналт шалгалтын удирдамжийн дугаар:

Хяналт шалгалт хийж эхэлсэн огноо:/...../.....

Хяналт шалгалт дууссан огноо:/...../.....

Хяналт шалгалт хийсэн огноо:/...../.....

Хууль сахин
мөрдөлтийн хувь:

Эрсдэл үүсэх
магадлал

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
Барилга байгууламжийн баримт бичгийн бүрдэлтэй холбоотой асуултууд			0	115	0	0
1	Барилгын тухай хуулийн 18.1, 20.2	Барилгын зураг төслийг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй.				
2	Барилгын тухай хуулийн 18.1, 20.2	Барилгын угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй.				
3	Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.1, 24.1.5, 22.1.2	Тухайн барилга байгууламжид хот суурины батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг үндэслэн газар эзэмших, ашиглах, өмчлөх захирамж гаргасан, нутгийн захиргааны байгууллагаас гэрчилгээ олгосон.	0	15		

4	Хот байгуулалтын тухай хуулийн 22.1.2, Барилгын тухай хуулийн 35.1.3	Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн хангамжийн боломж, эрүүл ахуй, галын аюулгүйн нөхцөл, шаардлагад нийцүүлэн тухайн барилга байгууламжийн байршлыг тогтоож баталгаажуулсан.	0	15		
5	"Аймаг, нийслэлийн Ерөнхий архитекторын дүрэм"-ийн 3.1.8, ББЗТБЗМХД-ийн 3.4	Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг баталсан.	0	10		
6	Барилгын тухай хуулийн 12.1.1, ББЗТБЗМХД-ийн 3.5, "Барилгын зураг. Архитектурын ажлын зургийг гүйцэтгэх дүрэм" MNS 3757-11 : 2014	Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн зургийн даалгаврыг боловсруулж баталсан.	0	10		
7	БТХ-ийн 37.9.3, 37.9.4, ББЗТБЗМХД-ийн 3.8	Барилга байгууламжийн нэг маягийн зураг, өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зургийн даалгавар, зураг төслийг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хянуулсан.	0	10		
8	БТХ-ийн 12-р зүйл, 23.2, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн 4.1, 4.2, 4.3, 5.1, 5.2, "Аймаг, нийслэлийн Ерөнхий архитекторын дүрэм"-ийн 3.1.8,	Барилгын эх загвар зураг /эскиз/-ыг архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зургийг үндэслэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар хянуулж, зөвшөөрөлцсөн.	0	10		

9	БТХ-ийн 23.2, 38.1.1, ББЗТБЗМХД-ийн 4 дүгээр зүйл, "Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага" MNS 3757-3 : 2013, "Барилгын зураг. Архитектурын ажлын зургийг гүйцэтгэх дүрэм" MNS 3757-11 : 2014, "Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага" MNS 3757-3 : 2013, "Барилгын зураг. Ажлын зургийн ерөнхий өгөгдөл" MNS 3757-4 : 2013	Барилгын ажлын зургийг эх загвар зураг, загвар зургийг үндэслэн боловсруулсан.	0	10		
10	БТХ-ийн 25.1, 37.1.10	Барилгын зураг төсөлд магадлал хийсэн.	0	10		
11	Барилгын тухай хуулийн 38.1.6, 40.1.17, 25.5, "Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага" MNS 3757-3 : 2013, "Барилгын зураг. Архитектурын ажлын зургийг гүйцэтгэх дүрэм" MNS 3757-11 : 2014, "Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага" MNS 3757-3 : 2013, "Барилгын зураг. Ажлын зургийн ерөнхий өгөгдөл" MNS 3757-4 : 2013	Барилгын ажлын явцад анхны зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн үе шатны ажил бүрд гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулсан.	0	10		
12	Барилгын тухай хуулийн 19.1.1, 37.1.3, 37.1.4, 37.1.5, 38.1.8, 23.4,	Тухайн барилга байгууламжийн захиалагч нь зураг төсөл зохиогчтой зураг төсөл боловсруулах болон хяналт тавих гэрээг байгуулсан.	0	5		
13	Барилгын тухай хуулийн 40.1.16, ХБТХ-ийн 22.1.2	Барилгын ажлын зөвшөөрөлтэй	0	10		
Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөтэй холбогдсон асуултууд			0	310		
14	Хот байгуулалтын тухай хуулийн 12.8, 12.6.1, 12.6.3, 24.1.5, ГТХ-ийн 56.1, 56.6 Барилгын тухай	Хот, суурин газрын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн.	0	15		

15	30.1, 30.3 Барилгын тухай хуулийн 12.1.8, 12.1.4 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн 3.2, 3.3, "Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах" MNS ISO 11091 : 2007	Зэргэлдээ барилга байгууламжийн архитектур төлөвлөлттэй уялдуулсан.	0	5		
16	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн 3.2, 3.3, "Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах" MNS ISO 11091 : 2007	Барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас ихгүй, зам, талбай, ногоон байгууламж 30 хувиас доошгүй байхаар тусгасан, авто зогсоол түүний орц гарцыг хөдөлгөөнд саадгүй байхаар төлөвлөсөн.	0	20		
17	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 2.11, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ийн 4.18, 5.26, 4 дүгээр хавсралт	Тухайн барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл нь: - Барилгын тууш талуудын хоорондох зай 15м-ээс багагүй /2-3 давхар бол/, 20м-ээс багагүй /4 давхар бол/, 21м-ээс багагүй /5 давхар/, 30м-оос багагүй /9 давхар/, 40м-ээс багагүй /12 давхар/, 45м-ээс багагүй /16 давхар/, - Барилгын тууш тал, хөндлөн талын хооронд болон сууцны өрөөний цонхтой хөндлөн талуудын хооронд 10м-ээс багагүй /2-4 давхар/, 12м-ээс багагүй /5 давхар/, 15м-ээс багагүй /9 давхар/, 18м-ээс багагүй /12 давхар/, 20м-ээс багагүй /16 давхар/, - Шулуун тэнхлэгийн дагуу байрласан цамхаг хэлбэрт барилгуудын хоорондох зай 18м-ээс багагүй /9-12 давхар/, 25м-ээс багагүй /16 давхар/ зайд байрлах шаардлагыг хангасан.	0	20		

	"Сургуулийн боловсролын байгууллагын төлөвлөлт" /БНБД 31-24-22/-ийн 4.1.6	Цэцэрлэгийн бие даасан барилга, орон сууц, олон нийтийн барилгад байрлах цэцэрлэгийн цонхноос зэргэлдээ орших барилга хоорондох зай хэмжээг хангаж төлөвлөсөн.Үүнд: - гудамж замын улаан шугамаас барилга хүртэлх зөвшөөрөгдөх зай хот суурин газарт 25 м-ээс багагүй, хөдөө орон нутагт болон нам давхар барилгажилттай газарт 10 м-ээс багагүй; - зэргэлдээ орших барилга, байгууламжийн хоорондын зайн хэмжээг галын аюулгүй байдал, байгалийн гэрэлтүүлэг, нарны тусгалын норм, норматив баримт бичгийн шаардлагыг хангаж байхаар тооцох ба 12 м-ээс багагүй; - 10 хүртэл тээврийн хэрэгслийн битүү болон ил зогсоолоос 25 м-ээс багагүй, харин 11 ба түүнээс дээш зогсоолоос 50 м-ээс багагүй; - авто зогсоол руу тээврийн хэрэгсэл орох, гарах гарц болон битүү ба ил зогсоолын агаар зайлуулах хоолойноос 15 м-ээс багагүй, - хоёрдогч түүхий эд цуглуулах цэг, хогийн цэгээс 50 м-ээс багагүй; - хийн түлшний хэрэглээг хангах зориулалттай шингэрүүлсэн шатдаг хийн нөөцийн савнаас БНБД 42-01-19-ийн шаардлагыг хангасан зайд;	0	20		
18	Барилгын тухай хуулийн 14.1.4	Зэргэлдээ орших барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулаагүй.	0	15		
19	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 3.5, Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө БНБД 30-02-07-ийн 2.12	Хорт бодис ялгаруулдаггүй, бохирдолгүй нормын зөвшөөрөгдөх хэмжээнд дуу шуугиан гаргадаг үйлдвэр, аж ахуйн газруудыг суурьшлын бүсэд байршуулахдаа орон сууцны барилга, амралт зугаалгын бүс, эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэгээс 50м-ээс багагүй зайд байрлуулсан.	0	15		
20	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 6.12	Орон сууцны эдэлбэр газраас төмөр зам хүртэлх ариун цэврийн хамгаалалтын бүсийн өргөн 50 м-ээс багагүй байхаар төлөвлөсөн.	0	15		
21	БНБД 31-01-10-ийн 4.16, 4-р хавсралт	Тухайн барилгын ил зогсоолыг тээврийн хэрэгслийн норматив шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	10		

22	БНБД 30-01-04-ийн 5.1, 13 дугаар хавсралт, БД 31-113-11-ийн 3-р бүлэг	Тухайн олон нийт, иргэний барилга байгууламжийн эдэлбэр газрын хэмжээнд тавигдах шаардлагыг хангасан.	0	15		
23	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 3.6, 3.7, "Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах" MNS ISO 11091 : 2007	Сургуулийн эдэлбэр газрын талбайн 50%-иас багагүй талбай нь ногоон байгууламж төлөвлөсөн, биеийн тамирын, аж ахуйн ба амралтын гэсэн 3 үндсэн бүсэд хуваасан.	0	10		
24	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 5.4	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын явах замыг, хурдны зам, гол гудамж замтай нэг түвшинд огтолцохоор төлөвлөөгүй.	0	10		
25	БНБД 23-04-07, БНБД 30-01-04-ийн 9.19	Тухайн барилгаас түүний зэргэлдээ байрлаж байгаа орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэрийн барилга байгууламжийн ерөө тасалгаанд тусах нарны тусгалын норматид шаардлагыг хангасан.	0	10		
26	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 4 дүгээр хавсралт	Тухайн барилга байгууламжаас түүний зэргэлдээ байрлаж байгаа орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэрийн байгууламж хүртлэх зай хэмжээ галын аюулаас хамгаалах шаардлагыг хангасан.	0	20		
27	БНБД 30-01-04-ийн 6.13, 10-р хүснэгт	Орон сууцны эдэлбэр газрын улаан шугамаас гудамж замын ирмэг хүртэлх зай хэмжээг хангасан.	0	10		
28	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 6.39	Тухайн барилга байгууламжийн хананаас түүний зэргэлдээ байрлаж байгаа шингэн түлш хадгалах газар доорхи сантай шатахуун түгээх станц хүртэлх зай хэмжээний шаардлагыг хангасан.	0	10		
29	ХБТХ-ийн 24.1.6, БНБД 30-01-04-ийн 7.10	Уг барилга байгууламжийг инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын гадна талд төлөвлөгдсөн.	0	15		
30	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.1	Ямар нэгэн онцгой, чухал объектоос өндөр барилга хүртэлх зай нь эдгээр барилгын нэгээс нөгөөд гал дамжих боломжгүйгээр барахгүй аль нэг нь нурахад үүсэх гал түймрээс хол байхаар төлөвлөсөн.	0	15		

31	БТХ-ийн 12.1.6, 15 дугаар зүйл, ХБТХ-ийн 20.2, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/-ийн 5.1, 5.2, 5.3, "Явган хүн	Тухайн барилга байгууламжийн гадна талбайн орцны хэсэг болон зорчих замд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дотогш саадгүй нэвтрүүлэхэд зориулж налуу замыг тавигдах шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	15		
32	хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага" MNS 5682: 2006	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тээврийн хэрэгслийн зогсоолыг тавигдах шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	15		
33		Амрах орон зай, байр ба тохижилтод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амрах, зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж төлөвлөсөн.	0	15		
34	ХБТХ-ийн 22.1.1, 13.1.7, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн 3.14	Улсын нөөцийн агуулах, 1-р группийн нефть болон нефтийн бүтээгдэхүүний дамжлага бааз, шингэн хийн агуулах, шатах дэлбэрэх материалын агуулах, хүчтэй хот бодисуудын суурь агуулах, хүнсний бүтээгдэхүүний суурь агуулах, бордоо ба үйлдвэрийн түүхий эд, ойн болон барилгын материалын агуулахыг хот, тосгоны нутаг дэвсгэрийн хилийн гадна эрүүл ахуй, гал түймрийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан тусгай зориулалттай агуулахуудын бүсэд байрлуулсан	0	15		
Барилга байгууламжийн доторх орон зайн төлөвлөлтэй холбогдох асуултууд			0	430		
35	БТХ-ийн 12.1.6, 15 дугаар зүйл, ХБТХ-ийн 20.2, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага MNS 6055:2009-ын 5.2, 5.3, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/-ийн 6.2, 6.5	Тухайн барилгын загвар зураг, эх загвар зураг, ажлын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангасан төлөвлөлтийг тусгасан. Үүнд: Орон сууц, олон нийтийн барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүний орох боломжийг хангасан налуу зам болон бусад тоног төхөөрөмжүүдээр тоноглогсон, тавигдах шаардлагын дагуу тээврийн хэрэгслийн зогсоол төлөвлөн, барьсан.	0	15		

36	БТХ-ийн 12.1.6, 15 дугаар зүйл, ХБТХ-ийн 20.2, MNS 6055:2009-ын 5.5, БНБД 35-01-22-ийн 6.2	Тухайн барилгын дотор хананд бариулыг тоноглон, хараагүй хүн явах, зүг чигээ тогтооход зориулж тод өнгөөр будсан зурвас бүсийг тэмдэглэсэн, хөтөч зам төлөвлөсөн.	0	10		
37	БТХ-ийн 12.1.6, 15 дугаар зүйл, ХБТХ-ийн 20.2, MNS 6055:2009-ын 5.6, БНБД 35-01-22-ийн 6.2, 6.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж том товчлуурыг товойлгон байршуулж, тоон цифрийг босоогоор тод томруун бичсэн, давхруудын байрлал, ерөө тасалгааны дугаарыг зарлах зориулалтаар цахилгаан шатны тасалгаа (кабин)-г дуу үүсгэгчээр тоноглон.	0	10		
38	БТХ-ийн 12.1.6, 15 дугаар зүйл, ХБТХ-ийн 20.2, MNS 6055:2009-ын 5.7, БНБД 35-01-22-ийн 6.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөг төлөвлөж, тоног төхөөрөмжөөр тоноглон.	0	15		
39	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ийн 4.13	Орон сууцны барилгын үндсэн орц, цонхтой нүүрэн талд нийтийн үйлчилгээний зориулалттай өрөө тасалгаа байрлуулж төлөвлөөгүй.	0	10		
40	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ийн 4.15	Хоёр талдаа цонхтой орон сууцны барилгад 10 хүртэлх хүүхдийн багтаамжтай гэрийн цэцэрлэгийн өрөө тасалгааг 2 хүртэлх давхарт байрлуулсан ба барилгын эдэлбэр газарт нь оршин суугчид болон хүүхэд амрах, тоглох тоглоом бүхий талбайтай төлөвлөсөн.	0	10		
41	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ийн 5.24	Барилгын цахилгаан шатыг унтлагын өрөөний ханатай зэрэгцээ байрлуулаагүй, бусад өрөө тасалгаатай зэрэгцээ төлөвлөсөн бол дуу чимээ тусгаарлах хийцлэлийн арга хэмжээ авсан.	0	15		
42	БНБД 31-01-10-ийн 4.9, 4.10, 3-р хавсралт	Орон сууцны барилгад цахилгаан шатны тоо, даац ба хурдын тооцож төлөвлөсөн.	0	10		

43	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ийн 9.3	Нийтийн орон сууцны барилгын хонгил аль нэг төгсгөлдөө цонхтой бол хонгилын норматив урт нормоор 24м, өргөн нь 1.4м, хоёр төгсгөлдөө цонхтой нөхцөлд урт нь 48м, 48м-ээс урт бол өргөн нь 1.6м, урт хонгилын 24м тутамд хөндлөн талаас нь байгалийн гэрэл тусах гэрлийн кармантай байх ба карманаас хонгилын төгсгөл хүртэл 30м төлөвлөсөн.	0	15		
44	БНБД 31-01-10-ийн 4.16, 4-р хавсралт	Тухайн барилгын доторх дулаан зогсоолыг норматив шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	10		
45	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 4.4, 4.5	Барилгын аюулгүй байдлыг иж бүрэн хангах удирдлагын төв, ашиглалтын албаны өрөөг барилгын гол орцны орчим, хөлийн өрөө болон утаажилтгүй шатны хонгил руу шууд гарцтайгаар 1-р давхарт, байгалийн гэрэлтүүлэгтэй байхаар байрлуулсан.	0	10		
46	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 4.7	Өндөр барилга болон түүнд залгасан барилга, орон зайд сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага төлөвлөөгүй.	0	10		
47	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 4.15	Гадна хана, фасадыг нил шилэн ханаар хийсэн бол дотор талд нь 1200 мм-ээс багагүй өндөртэй хашлага төлөвлөсөн.	0	10		
48	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.7	Гал тэсвэршлэх ханаар хязгаарлагдсан газраас дээшхи хэсгийн хамгийн их талбай зочид буудалд 1500м ² , орон сууцанд 2000м ² , бусад 2500м ² -аас ихгүй байхаар төлөвлөсөн.	0	10		
49	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.9	Барилгын 50м-ээс дээш өндөрт байрлах олон нийтийн зориулалттай танхим 100-аас ихгүй хүний багтаамжтай төлөвлөсөн.	0	10		
50	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.20, 14.22	Өндөр барилга дахь айлын орон сууцны хаалганаас хамгийн ойр байрлах утагдаггүй шатны хонгилын хаалга хүртэл 12м-ээс ихгүй төлөвлөсөн.	0	10		
51	БНБД 31-01-10, БНБД 31-17-10, БНБД 31-03-03, БНБД 21-05-10	Барилгаас хүмүүсийг түргэн хугацаанд нүүлгэн шилжүүлэх гарц болон төлөвлөлтийн тавигдах шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	15		

52	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 1.7	Дуу чимээ, чичиргээ үүсгэдэг тоног төхөөрөмжөөр ажиллах салхивчийн өрөө, шахуурга болон дулааны узелийн өрөөг үзвэрийн танхим, бэлтгэл сургуулилт хийх өрөө, тайз, дууны төхөөрөмжийн өрөө, уншлагын танхим, эмнэлэгийн тасаг, эмчийн өрөө, мэс заслын өрөө, цэцэрлэгийн группийн өрөө, хичээллэх анги танхим болон тогтмол хүнтэй байдаг өрөөний харалдаа дээр, доор, зэрэгцүүлэн байрлуулж төлөвлөөгүй.	0	15		
53	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 1.11	Цахилгаан шат ажиллуулах төхөөрөмжийн өрөө болон шатны хонгилийг сургуулийн өмнөх насны хүүхдийн өрөө, сургалтын байгууллагын анги, танхим, олон нийтийн тогтоомол хүнтэй байдаг кабинеттай шууд тулгаж төлөвлөөгүй.	0	15		
54	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 2.2, 2.5	Цэцэрлэгийн барилгын өрөө, тасалгааны нэг хүүхдэд ноогдох талбайг тооцож төлөвлөсөн.	0	10		
55	"Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНБД 31-24-22/	Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт сургууль, ерөнхий боловсрол, тусгай мэргэжил нэгэн зэрэг олгох политехникийн дунд сургуулиас бусад сургалтын байгууллагыг байнгын хөдөлгөөнтэй замаас 50м-ээс, орчных нь гудамж замаас 25м-ээс хол зайтай байрлуулан төлөвлөсөн.	0	15		
56	"Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНБД 31-24-22/ 6 дугаар зүйл	Цэцэрлэгийн барилгын өрөө тасалгааны байгалийн болон зохиомол гэрэлтүүлгийн шаардлагыг хангасан.	0	15		
57	"Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНБД 31-24-22/ 5 дугаар зүйл	Тухайн барилгын эзэлхүүн төлөвлөлтийн шийдэлд тавигдах шаарлагыг хангасан.	0	10		

58	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 2.4	Орон сууцны барилгад байрлах сургуулийн өмнөх насны хүүхдийн бүлгийн өрөөний 1 хүүхдэд 4 ам/м-ээс багагүй талбай ноогдохоор тооцож өлгүүр, амралтын өрөө, тогтоомын өрөө, ариун цэврийн өрөө, ажилчдын цайны газартай байхаар төлөвлөсөн.	0	10		
59	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 2.7, 2.16, 2.19, 2.21	Сургалтын барилгын өрөө болон номын сангийн нийтийн уншлагын танхимын нэг хүүхдэд ноогдох талбайн шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	10		
60	БНБД 31-03-03-ын 2.8, ЕБСБТ БД 31-113-11	Ерөнхий боловсролын сургуулийн барилгаас тухайн сургуульд хамааралтай авто зогсоол хүртэлх зайг авто тээврийн хэрэгсэлийн хүчин чадалтай уялдуулан төлөвлөсөн.	0	10		
61	БНБД 31-03-03-ын 2.8, БНБД 31-25-22	Сургуулийн барилгын эзэлхүүн төлөвлөлтийн шийдэлд тавигдах шаардлагыг хангасан.	0	10		
62	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 4.9, 3.4, ЕБСБТ БНБД 31-25-22	Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн барилгын хүчин чадал, гал тэвсвэршилтийн зэргээс хамааруулан давхрын хэмжээг тооцож төлөвлөсөн.	0	10		
63	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 2.12	Сууцны болон соёл, олон нийтийн ажлын өрөөний дээд, доод талд агуулахын өрөө, хадгаламжийн өрөө, галын аюултай өрөө байрлуулан төлөвлөөгүй.	0	15		
64	БНБД 31-03-03-ын 2.9, 1.24, Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх БНБД 31-22-21-ийн 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл	Эмнэлэгийн барилгын нэг оронд ногдох талбайн хэмжээ болон барилгад тавигдах шаардлагыг хангасан.	0	10		
65	БНБД 31-03-03-ын 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.18	Үзвэрийн болон нийтлэг үйлчилгээ, хурлын, соёлын танхимуудын нэг суудалд ноогдох талбайд тавигдах шаардлагыг хангасан.	0	10		
66	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 2.22	Олон нийт, иргэний барилгын хооллох танхимын нэг суудалд ноогдох талбайд тавигдах шаардлагын дагуу төлөвлөсөн.	0	10		
67	БНБД 31-04-12-ын 5.1, 5.5	Захиргааны зориулалттай барилгын өрөө, тасалгаануудыг иж бүрэн төлөвлөсөн.	0	10		

68	"Захиргааны зориулалттай олон нийтийн барлига" БНБД 31-04-12-ын 5.2, хавсралт Д	Захиргааны зориулалттай олон нийтийн барилга байгууламжийн өрөөний талбайд тавих шаардлагыг хангасан.	0	10		
69	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 2.13	Театр, концертын танхимын нэг суудалд ногдох талбайг тооцож төлөвлөсөн.	0	10		
70	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын 3.25	Соёл, үзвэрийн барилгын давхрын хязгаар, хүчин чадал, гал тэсвэршилтийн зэргийн хоорондын хамаарлыг тооцож төлөвлөсөн.	0	10		
71	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03	Театрын барилгын тайзны төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангасан.	0	10		
72	Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03	Кино үзвэрийн танхим, дэлгэцийн төлөвлөлтөд тавигдах шаардлагыг хангасан.	1	10		
Барилгын угсралт, орчны тохижилт			0	40	0	
73	Барилгын тухай хуулийн 40.1.1, Хот байгуулалтын тухай хуулийн 22.1.2, 24.1.4	Батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн.	0	20		
74	Барилгын тухай хуулийн 40.1.1, Барилгын орчны тохижилтын ажил БНБД 31.01.08-98, Үйлдвэрийн газрын барилгажилтын ерөнхий төлөвлөгөө БНБД 30-02-07-ийн 3.38 - 3.53, 3.70 - 3.86, "Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах" MNS ISO 11091 : 2007,	Амралтын болон хүүхдийн тоглоомын талбайн тоног төхөөрөмжийн угсралтыг зураг төслийн дагуу гүйцэтгэсэн.	0	5		
75		Авто болон явган хүний зам талбайг гүйцэтгэхдээ зураг төслийн дагуу гүйцэтгэсэн	0	5		
76		Ногоон байгууламжийг зураг төслийн дагуу хийгдсэн.	0	5		
77		Гадна зам талбайн гэрэлтүүлгийг зураг төслийн дагуу хийгдсэн.	0	5		
НИЙТ ОНОО			0	895	0	0
БАТАЛГААЖУУЛАЛТ						
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр		Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан			
/ овог, нэр/		/ овог, нэр/	/ овог, нэр/			
/ гарын үсэг, тэмдэг/		/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/			